

ЭДИЙН ЗАСАГ

**ЭЗХТЗ-ИЙН ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭН  
ДЭХ БНМАУ-ЫН ХӨГЖЛИЙН  
ХУРДАЦ**

Эдийн засгийн ухааны доктор  
Х. ДАШДОНДОВ

Орчин үед дэлхийн социалист систем хүн төрөлхтөний нийгмийн дэвшил хөгжлийн шийдвэрлэгч хүчин зүйл болон улам бүр батжин бэхжиж улс төр, эдийн засаг, соёлын амьдралын бүх хүрээнд олон улсын харилцааны шинэ маягийн хэлбэр болжээ. Ялангуяа сүүлийн жилүүдэд ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын эдийн засгийн нөөц бололцоо үлэмж өсч, ард түмнийх нь чинээлэг аж байдал дээшилж, соёл, шинжлэх ухаан эрчимтэй хөгжиж байна.

Социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хоорондын бүх талын хамтын ажиллагаа, харилцан туслалцдаг зарчим, шинэ нийгэм байгуулахад олж байгаа баялаг туршлагаа харилцан солилцдог уламжлалт сайхан заншил нь эдгээр орны ард түмний амьдралын бүхий л үйл ажиллагаанд ахиц гаргах бодит нөхцлийг бүрдүүлж байна. Энэ нь ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын эдийн засаг, улс төрийн амьдралыг улам ойртуулан жигдрүүлэх сайхан боломжийг буй болгожээ.

БНМАУ-ын эдийн засгийн бүх салбарт социалист үйлдвэрлэлийн харилцаа амжилттай ялж, ард түмний материалын болон соёлын түвшин дээшилсэний үр дүнд 1960-аад оны эхээр манай улс феодализмаас социализмд шилжих шилжилтийн үеийг бүрэн дуусгаж, социалист байгуулалтынхаа цоо шинэ үе шатыг эхэлсэн билээ. Ид энэ үед буюу 1962 онд БНМАУ ЭЗХТЗ-д гишүүнээр элсэн орж ах дүү социалист бусад орнуудтай олон талаар ЭЗХТЗ-ийн хүрээнд хамтран ажиллах болсон нь үндэснийхээ эдийн засгийн хурдцыг түргэтгэх, ард түмнийхээ амьдралын түвшинг улам дээшлүүлэхэд бүр ч их онцгой ач холбогдолтой болсон юм.

ЭЗХТЗ-ийн хүрээнд эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хоёр болон олон талын нягт хамтын ажиллагаа тав таван жилээр өргөжин хөгжиж, шинэ шинэ хэлбэр агуулгаар улам бүр баяжиж ирсэн нь БНМАУ-ын эдийн засгийг түргэн хурдацтай хөгжүүлэх, түүний үр ашгийг дээшлүүлэхэд онцгой нөлөө үзүүлсэн болно. БНМАУ, ЭЗХТЗ-д бүрэн эрхт гишүүнээр элссэнээс хойшхи 25 жилийн хугацаанд манай орон олон улсын хөдөлмөрийн социалист хувиарын давуу талыг аль болох бүрэн ашиглаж, ЗХУ болон хамтын нөхөрлөлийн ах дүү бусад оронтой улс ардын аж ахуйн төлөвлөгөөг уялдуулан зохицуулж, тэдэнтэй хоёр болон олон талаар нягт хамтран ажиллах замаар социалист нийгмийн байгуулалтын нарийн төвөгтэй зорилтыг амжилттай шийдвэрлэж байна.

ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын Коммунист, ажилчны намын удирдагчид, засгийн газрын тэргүүн нарын хэмжээнд хуралдсан ЭЗХТЗ-ийн XXI (тусгай) чуулганаас хамтын ажиллагааны цаашдын зорилт, зарчмын чиглэлийг тодорхойлсон бөгөөд түүний дагуу 1971 онд зөвлөлийн XXV чуулганаар ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагааг цаашид улам гүнзгийрүүлэн боловсронгуй болгож, социалист эдийн засгийн интеграцыг хөгжүүлэх цогцолбор программыг баталсан билээ.

Ингэж социалист эдийн засгийн интеграцыг хөгжүүлэх нь олон улсын хөдөлмөрийн социалист хувиарыг хэрэгжүүлэх, ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын үндэсний аж ахуйн орчин үеийн өндөр үр ашигтай бүтэц бүрдүү-

лэх, тэдгээр орны хөгжлийн түвшинг аажмаар ойртуулан жигдрүүлэх, эдийн засаг шинжлэх ухаан техникийн салбарт тогтвортой, гүнзгий уялдаа холбоо тогтоох, социалист зах зээлийг өргөтгөн бэхжүүлэх явдлыг алс хэтийн төлөвлөгөөтэй зохицуулах үйл явц байлаа.

Орчин үеийн нөхцөлд ЭЗХТЗ-ийн орнуудтай БНМАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх гол чиглэл нь социалист эдийн засгийн интеграц болж байна. Энэхүү интеграц нь социалист хамтын нөхөрлөлийн орнуудын эдийн засгийг өрнүүн хөгжүүлэх үндсэн хүчин зүйл болохын хамт аж үйлдвэрийн талаар арай сул хөгжсөн ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын эдийн засгийн өсөлтийг илүү хурдасгах нөхцөл бүрдүүлж байгаагаараа онцлогтой юм. Хөгжлийнхээ өвөрмөц нөхцлийн улмаас ийм орны тоонд хамаарсаар байгаа БНМАУ-ын талаар социалист эдийн засгийн интеграцыг хэрэгжүүлж эхэлсэн бүр анхны үеэс аваад онцгой анхаарал тавьж, хамтын ажиллагааны хувьд давуу нөхцөл бүрдүүлж өгсөн билээ. Энэ нөхцөл байдлыг социалист эдийн засгийн интеграцын цогцолбор программд тусгайлан зааж: «ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын эдийн засгийн хөгжлийн хэмжээгээр аажмаар ойртуулан жигдрүүлэх ерөнхий асуудлын хүрээнд БНМАУ-ын эдийн засгийг түргэн явцтай хөгжүүлэх асуудал онцгой байр эзэлж байна» гэсэн билээ.

Цогцолбор программд заасан БНМАУ-д холбогдох тусгай арга хэмжээ, эдгээрийг хэрэгжүүлэх тодорхой арга зам нь социалист интеграцын хамтын нэгдэл, томоохон асуудлыг социалист интернационализмын зарчмын үзэл санаагаар шийдвэрлэж байгааг нотлох тод жишээ мөн. Эдгээр арга хэмжээ нь социализмыг бүрэн байгуулах үеийн МАХН-ын эдийн засгийн бодлогын стратегийн чиг шугамд бүрэн дүүрэн нийцэж, тус орны хөгжлийн замд тохиолдож болох бодит бэрхшээлийг давахад тус дөхөм үзүүлэн, манай байгалийн нөөц баялагийг нийт социалист хамтын нөхөрлөлийн эрх ашгийн үүднээс үр нөлөөтэй ашиглах бололцоо олгож байна.

ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн ах дүү бусад орны эдийн засгийн тусламж дэмжлэг, өөрийн ард түмний бүтээлч хөдөлмөрийн уг дүнд БНМАУ-ын эдийн засаг харьцангуй өндөр хурдацтай хөгжиж, эдийн засгийн чадавхи боломж нэмэгдсээр байна. Одоо манай улсын үндэстний орлогын өсөлтийн хурдац ЭЗХТЗ-ийн гишүүн бусад орны өндөр түвшингийн үзүүлэлтэд хүрч чадлаа. Хэрэв 1961—1965 онд манай улсын үндэстний орлогын жил дутмын өсөлтийн хурдац нь 1,1% байсан бол 1966—1970 онд 4,3 %, 1971—1975 онд 6,7 %, 1976—1980 онд 5,5% 1981—1985 онд 6,5 % болж өсөв. Социалист эдийн засгийн интеграцыг хөгжүүлэх цогцолбор программд заагдсан БНМАУ-ын эдийн засгийн хөгжлийг түргэтгэж, түүний үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн тусгай арга хэмжээг ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд, зөвлөлийн байгууллагуудаас тодорхой төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлж байна.

БНМАУ-ын мал аж ахуйг эрчимжүүлж, мал аж ахуйн зарим төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд үйлдвэрийн арга нэвтрүүлэх тухай цогцолбор программын арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ЭЗХТЗ-ийн хүрээнд их ажлыг хийв.

Манай улсын мал сүргийг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах зорилгоор ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын 300 орчим мэргэжилтэн оролцсон мал эмнэлгийн иж бүрэн экспедиц байгуулан ажиллуулж, давхардсан тоогоор 37 сая гаруй малд үзлэг шинжилгээ хийсэн нь үр дүнтэй болов.

ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын мэргэжилтэн, эрдэмтэд манай геологчидтой хамтран тус улсын геологийн тогтоц, зарим чухал ашигт малтмалын ордын байршлын зүй тогтлыг судлах талаар эрдэм шинжил-

гээний их ажил хийх, ховор ба үнэт металл, хайлуур жоншны шинэ орд нээх ирээдүй бүхий талбайг тодорхойлсон нь цаашид геологийн үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний ажил явуулах чиглэлийг тооцоолоход чухал ач холбогдолтой болсон юм. Мөн Хэрлэнгийн хойт районд ЭЗХТЗ-ийн олон улсын геологийн экспедиц судалгаа хийсний дүнд гянтболд, цагаан тугалга, бал чулуу, хайлуур жоншны зэрэг 20 шахам ордыг илрүүлэв.

БНМАУ, ЭЗХТЗ-ийн гишүүн бусад орны хоорондын харилцаанд гадаад худалдааны дамжин өнгөрөх ачаа тээврийн хөнгөлөлттэй тарифыг манай улсын хувьд тогтоон хэрэглэж байна.

ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд БНМАУ-д шинжлэх ухаан техникийн мэдээллийн төв, радио электроникийн болон хими-технологийн лаборатори зэрэг эрдэм шинжилгээний 12 объект байгуулах, түүнд ажиллах боловсон хүчин бэлтгэхэд буцалтгүй тусламж үзүүлэв. Мөн ЗХУ ба социалист хамтын нөхөрлөлийн бусад улсууд манай улсын экспортын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүн мал, маханд гадаад худалдааны урамшууллын үнэ тогтоосон юм. ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотод хүнсний барааны их дэлгүүрийг барьж ажиллуулсан нь хотын хөдөлмөрчдийн үйлчилгээний төв болов. Олон улсын хамтын ажиллагааны банк, олон улсын хөрөнгө оруулалтын банкнаас манай улсад хөнгөлттэй зээл олгох байгаа бөгөөд энэ зээлээр Улаанбаатар хотод ноос угаах фабрик баригдсан юм. Жилдээ 6 мянган тонн ноос угаах хүч чадалтай орчин үеийн машин техникээр иж бүрэн тоногдсон энэ фабрик нь үйлдвэрийн ба ажилчдын ажиллах нөхцлийг бүрэн хангаснаараа хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэн, өөрийн өртгийг хямдруулж, ашигтай ажиллах боломжтой юм.

ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагааны урт хугацааны зорилтот программд БНМАУ-ын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн нэлээд чухал арга хэмжээ тусгагдсан нь ах дүү орнуудын хамтын ажиллагааны интернационалч шинж чанарын бас нэг тод илрэл боллоо. Эдгээр арга хэмжээнд тухайлбал, Таван-толгойн коксждог нүүрс, Хөвсгөлийн фосфорит, Цагаан Суваргын зэс молибдены орд газрыг зөвлөлийн гишүүн сонирхогч орнуудтай хамтран ашиглах асуудлыг боловсруулах, олон улсын геологийн экспедицийн үйл ажиллагааг цаашид үр гэлжлүүлэх, говийн бүсийн умард хэсэг, халх голын районд атар газар эзэмлэх зэрэг асуудал орсон юм.

Одоо зөвлөлийн холбогдох байгууллагын шугамаар урт хугацааны зорилтот программын БНМАУ-д хамаарах арга хэмжээг тууштай хэрэгжүүлж байна.

ЗХУ, хамтын нөхөрлөлийн бусад орон тус улсын социалист байгуулалтад хоёр талын үндсэн дээр ихээхэн тусламж дэмжлэг үзүүлж байна. Монгол зөвлөлтийн хамтын ажиллагааны үр ашигтай уламжлалт хэлбэр болсон хамтын үйлдвэр, аж ахуйг байгуулан хөгжүүлэх үйл ажиллагаа социалист эдийн засгийн интеграцыг хөгжүүлэх цогцолбор программын үндсэн дээр улам өргөжиж байна.

Ер нь ардын хувьсгалын анхны жилүүдээс эхлэн ЗХУ манай улсын эдийн засгийн хөгжилд шийдвэрлэх ач холбогдолтой аж үйлдвэр, хөдөө аж ахуй, барилга, нийгэм соёл, ахуйн үйлчилгээний болон бусад салбарын олон зуун үйлдвэр, аж ахуйн газрыг байгуулж өгсөн бөгөөд байгуулсаар байгааг манай ард түмэн өндрөөр үнэлдэг юм. Хоёр орны хамтын ажиллагааны цар хүрээ улам өргөжин тэлж, одоо бүхэл бүтэн хот, үйлдвэрийн район, сангийн аж ахуй, орон сууцны хорооллыг сургууль, эмнэ

лэг, ахуйн үйлчилгээний төвийн хамт иж бүрнээр барьж байгуулдаг боллоо. ЗХУ, ЭЗХТЗ-ийн бусад орны хамтын хүчээр Дархан, Чойбалсан, Эрдэнэт, Багануур, Бор Өндөр, Хөтөл зэрэг аж үйлдвэрийн шинэ шинэ төв байгуулсан нь ах дүү улсуудын үр бүтээлт хамтын ажиллагааны яруу тод илрэл мөн.

Зэс молибдены томоохон орд газрыг ашиглан Монгол-Зөвлөлтийн хамтын ажиллагааны түүхэнд хамгийн том уулын баяжуулах «Эрдэнэт» комбинатыг барьж ашиглалтанд оруулсан нь байгалийн баялагийг эзэм шихэд ах дүү улс орны хүчин чармайлтыг нэгтгэх явдал асар их ач холбогдолтойг тодорхойлох бодит жишээ юм.

Энэ үйлдвэр цар хэмжээгээрээ дэлхийн ийм төрлийн хамгийн том гэгдэх 10 үйлдвэрийн тоонд орж байгаа юм.

Энэ комбинатын бүрэн хүч чадлыг ашиглалтанд оруулахын хамт тус орны аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, санхүү, экспортын нөөц бололцооны нийт хэмжээ ихээхэн нэмэгдэх болно. Монголын нутаг дэвсгэрт зарим төрлийн эрдэс түүхий эдийн ордыг нээж олохын тулд БНАГУ, БНБАУ, БНСЧСУ-тай хамтран ажиллаж байна.

Монгол-Зөвлөлтийн эдийн засгийн хамтын ажиллагаа нь БНМАУ-ын эдийн засгийн хөгжлийн зангилгаа асуудлуудыг шийдвэрлэх, түүний бүтцийг төгөлдөржүүлэх, монголын ард түмний материаллаг аж байдал, соёлын түвшинг дээшлүүлэхэд чиглэгдэж байна. Ялангуяа ЗХУ манай орны эдийн засгийн гол салбарын нэг хөдөө аж ахуйн материал техникийн баазыг бэхжүүлэх, үйлдвэрлэлийн тогтвортой өндөр өсөлтийг хангах, ХАА-н гаралтай түүхий эдийг аж үйлдвэрийн аргаар иж бүрэн боловсруулах хөнгөн, хүнсний үйлдвэрийг шинээр барьж байгуулах, өргөтгөж шинэчлэх, хүч чадлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн олон чухал арга хэмжээг хамтран хэрэгжүүлж байна. Үүний дүнд тус улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд бүтцийн дэвшилт өөрчлөлт гарч, бүтээгдэхүүний үйлдвэрлэл тасралтгүй өсч, нэр төрөл нь олшрон ХАА-н түүхий эдийн аж үйлдвэрлэлийн борлуулалтын түвшин улам нэмэгдсээр байна. Өнгөрсөн 25 жилд газар тариалан биеэ даасан шинэ салбар болон эрчимтэй хөгжив. Атар газар эзэмших, сангийн аж ахуйг байгуулах, ХАА-н аяллыг механикжуулах зэрэг нь тус улсын гурил болон газар тариалангийн бусад төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээг хангах асуудлыг үндсэнд нь шийдвэрлэв.

ЗХУ-ын тусламжтайгаар манай орны үйлдвэрлэх хүчний хөгжилд шийдвэрлэх рольтой, экспортын нөөцийг арвижуулахад жинтэй хувь нэмэр болох түлш-- эрчим хүч, уул уурхайн болон аж үйлдвэрийн бусад зарим салбарыг хөгжүүлэх ажил улам эрчимжиж байна. Өнгөрсөн 25 жилд улс ардын аж ахуйн 600 объектыг барьж байгуулав. Мөн ЗХУ-ын тусламжтайгаар орон сууцны барилгыг өргөн далайцтай барьж байна.

ЭЗХТЗ-ийн гишүүн бусад орон манай орны улс ардын аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд интернационалч тусламж дэмжлэг үзүүлж байгаа нь үр дүнгээ өгсөөр байна. БНБАУ-ын тусламжтайгаар мах комбинат, нэхий, нэхий эдлэлийн үйлдвэр, шилэн дарлага бүхий хүнсний ногооны газар зэргийг барьж байгуулсан бөгөөд Орхон Шарын голын жимс ногооны аж ахуйн иж бүрэн цогцолбор байгуулав.

БНУАУ-ын тусламжтайгаар биокомбинат барьж байгуулсан ба тус орны бэлчээр нутгийг усжуулах ажил хийгдэж байна. БНАГУ-ын тусламжтайгаар гүн хэвлэл, хивсний үйлдвэр, мах консервын комбинат барьж байгуулсан ба Борнуурын САА-г өргөтгөн шинэтгэсэн юм. Манай хоёр орны хамтын хүч хөрөнгөөр Салхитын холимог металлын орд газарт геологи хайгуулын ажил явуулав.

БНПАУ-ын тусламжтайгаар мод боловсруулах комбинат, хөнгөн бе-

тоны завод, царууц тоосго, шохойн үйлдвэр, автомашины засварын газар барьж ашиглалтанд оруулав.

БНСРУ-ын тусламжтайгаар улсын циркийн барилга барьсан бөгөөд мебель-картон үйлдвэрлэх фабрик барьж ашиглалтад оруулав.

БНСЧСУ-ын тусламжтайгаар гутал, арьс ширний үйлдвэр, цементийн завод, Улсын клиникийн төв эмнэлэг, Баян-Өлгий аймгийн радио станц зэрэг аж үйлдвэр, нийгэм соёлын газруудыг барьж байгуулав.

ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орны их, дээд тусгай мэргэжлийн дунд сургуулиудад Монголын олон мянган залуучууд суралцаж төрөл бүрийн мэргэжил эзэмшиж байгаагийн дээр олон зуун ажилтан ажилчид тэдгээр орны улс ардын аж ахуйн салбаруудад дадлага хийж мэргэжлээ дээшлүүлж байна. Мөн тэдгээр орны олон зуун мэргэжилтэн манай оронд ирж ажиллан өөрсдийн баялаг туршлагаа эзэмшүүлж байна.

ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай хөгжүүлж байгаа үр ашигтай хамтын ажиллагаа нь манай орны нийгэм-эдийн засгийг түргэн хурдацтай хөгжүүлэхэд улам өргөжсөөр байна.

Материаллаг үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэлийн үндсэн фонд эрчимтэй шинэчлэгдэн, үйлдвэрлэлийн нэгжүүдийн хэмжээ зохисжиж, нийгмийн хөдөлмөрийн бүтээмж дээшилж байна. Өнгөрсөн 25 жилд улс ардын аж ахуйн үндсэн фонд 10,5 дахин, хөрөнгө оруулалт 7,7 дахин, хөдөлмөрийн бүтээмж 2,8 дахин, үүний дотор аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн үндсэн фонд 25.7 дахин, ажиллагчдын хөдөлмөрийн бүтээмж 3.3 дахин нэмэгдэв. Энэ хугацаанд нийгмийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4,3 дахин, үндэсний орлого 3.2 дахин, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 9,2 дахин, ХАА-н нийт бүтээгдэхүүн 1,7 дахин, гадаад худалдааны эргэлт 7.8 дахин өслөө.

Үндсэн фондод тооны өсөлтийн зэрэгцээгээр чанарын дэвшилтэт өөрчлөлт гарч одоо технологийн цоо шинэ бүтэц бүхий үндсэн фонд бүрдэв. Энэ нь юуны өмнө орчин үеийн машин, тоног төхөөрөмж, автомат шугам, машины бүхэл бүтэн систем бүхий том том үйлдвэрүүд буй болсон явдал мөн. Мөн тус улсын үндэсний орлогын бүтцэд (1985 оны байдлаар) аж үйлдвэр 32,4 %, хөдөө аж ахуй 18,3 %; барилга 4,9 %, тээвэр, холбоо 11,2 %, худалдаа, бэлтгэл, материал техникийн хангамж ба бусад салбарууд 33,2 хувийг тус тус эзэлж байна. Манай орны эдийн засгийн уламжилт ХАА-н салбар нь хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр, аж үйлдвэрийг түүхий эдээр бүрэн хангаж байгаагийн дээр эх орны экспортод чухал үүрэг гүйцэтгэж байна.

Аж үйлдвэр тус орны эдийн засгийн шийдвэрлэх салбар болон хөгжиж, одоо аж үйлдвэрийн бүтээгдэхүүн нийгмийн нийт бүтээгдэхүүнд 45,9 %, хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд 75,1 хувийг эзлэх болов.

Одоо манай аж үйлдвэр 1922 оны жилийн туршид үйлдвэрлэж байсан бүтээгдэхүүнийг 10 минутанд, 1940 оныхныг 7 өдөрт үйлдвэрлэж байна. Хэрэв 1940 онд барилга, тээвэр, холбоо, худалдаа бэлтгэл зэрэг салбар үндэсний орлогын дөнгөж 10 хувийг үйлдвэрлэж байсан бол одоо 49,3 хувийг эзлэж байна. Энэ бүхний дүнд манай орны улс ардын аж ахуй үйлдвэржих чиглэлээр түргэн явцтай хөгжиж, ард түмний материаллаг аж байдал, соёлын түвшин улам дээшилж байна. Одоо БНМАУ эдийн засаг, соёлын өсөлтийн нэлээд үзүүлэлтээр Ази, Африкийн урьд адил түвшинд байсан хогигиж байгаа орнуудаас хол түрүүлж байгаагаар барахгүй зарим үзүүлэлтээр дэлхийд ч тэргүүн байранд ордог орны тоонд орж байна. Тухайлбал, нэг хүнд ноогдох малын тоогоор дэлхийд нэг дүгээрт, эрчим хүч үйлдвэрлэлтээр Ойрхи Дорнод ба Азийн орнуудын дундаж түвшингээс давж байгаа бөгөөд нүүрс гаргалтаар дэлхийн дундаж

түвшингээс 1,5 дахин давж байна. Мөн нэг хүнд ноогдох мах, гурил ба хүнсний бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлтээр дэлхийн дундаж түвшингээс давж байна. Бас 10000 хүнд ноогдох суралцагчид, эмч, мэргэжилтний тоогоор ах дүү социалист орнуудын түвшинд хүрсэн ба хөгжингүй капиталист нэлээд улсаас түрүүлж байна. Энэ нь улс ардын аж ахуйн хөгжил, ард түмний амьдралын түвшин өндөр үзүүлэлтэнд хүрснийг харуулж байна.

Монголын ард түмний бүтээлч хөдөлмөр, ЗХУ болон ЭЗХТЗ-ийн гишүүн бусад орны социалист хамтын ажиллагаа, тусламж дэмжлэгийн үр дүнд БНМАУ-ын эдийн засаг, нийгмийг 1981—1985 онд хөгжүүлэх VII таван жилийн төлөвлөгөө амжилттай биелэв. Өнгөрсөн таван жилд Манай орны улс ардын аж ахуйн материал техникийн бааз нэлээд бэхжиж, эдийн засгийн потенциал өслөө. Манай орны давшингуй хөгжилд шинэ таван жил (1986—1990 он) чухал үе шат болох юм. Улс ардын аж ахуйн өндөр үр ашигтай бүтэц бий болгох, манай орны эдийн засаг, нийгмийг хөгжлийн илүү өндөр өсөлтөд хүргэх зорилтыг хэрэгжүүлэхэд ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай, юуны өмнө ЗХУ-тай хамтран ажиллах нь урьдын адил шийдвэрлэх ач холбогдолтой байх болно.

ЭЗХТЗ-ийн орнуудын шинжлэх ухаан техникийн дэвшлийн 2000 он хүртэлх цогцолбор программ манай оронд шинжлэх ухаан техникийн дэвшлийг түргэсгэх, түүний үр дүнг улс ардын аж ахуйд нэвтрүүлэх, манай эдийн засгийн өсөлтийг хурдасгах, үр ашгийг дээшлүүлэх нэмэлт боломжийг нээж байна.

1921 оны ардын хувьсгалаар Монгол оронд урьд өмнө үзэгдээгүй шинэ замд орсон нь феодализмаас капитализмыг алгасаж социалист дэвшилд шилжих зам байлаа. Энэ замд ардын хувьсгалт намынхаа удирдлагаар Монголын ард түмний олсон бүхий л ололт амжилт бол БНМАУ эхлээд социализмын ууган орон—ЗХУ-тай, дараа нь социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой үнэнхүү тэгш эрх, ах дүү ёсны шинэ харилцаа тогтоосоны үр дүн мөн болохыг туршлага нотлон харуулав. Үүнд л социалист хамтын нөхөрлөлийн салшгүй хэсэг болсон БНМАУ-ын хөгжлийн олон улсын ач холбогдлын нэг тод жишээ оршиж байгаа юм.

ЗХУ болон ах дүү бусад орнуудтай бүх талын хамтын ажиллагааны гүнзгийрэлт, интеграцчилах процессын хөгжилт нь манай орны эдийн засгийн хөгжлийн түвшинг ЭЗХТЗ-ийн гишүүн бусад орны түвшинд ойртуулан жигдрүүлэх, БНМАУ-ыг үйлдвэр— хөдөө аж ахуйн орон болгох намын программын зорилтыг амжилттай шийдвэрлэх найдвартай үндэс мөн.